

UCS 1001C:2020

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ХҮРТЭЭМЖТЭЙ ДЭД БҮТЭЦ



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд
хүртээмжтэй дэд бүтцийн зураг төсөл

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ХҮРТЭЭМЖТЭЙ ДЭД БҮТЭЦ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд
хүртээмжтэй дэд бүтцийн зураг төсөл



ГАРЧИГ

1. Зорилго.....	4
2. Хамрах хүрээ	4
3. Норматив эшлэл	4
4. Нэр томъёо, тодорхойлолт	4
5. Ерөнхий шаардлага	5
6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эргономик, антропометр	5
6.1. Тэргэнцрийн эзлэх орон зай	5
6.2. Тэргэнцрийн стандарт хэмжээ	7
6.3. Тэргэнцэртэй хүний ерөнхий хэмжээ, эргономик	8
6.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний антропометр.....	10
6.5. Таягтай хүний антропометр	12
7. Хот суурин газрын орон зайд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан төлөвлөлт ..	12
7.1 явган хүний гарц, зам талбай.....	12
7.2 явган хүний зам.....	13
7.3 авто машины зогсоол	14
8. Нийтийн тээврийн зогсоол	16
8.1 нийтийн тээврийн хэрэгслийн дотоод орон зай, тоноглол	20
8.2 галт тэрэг.....	21
9. Хөгжлийн бэрхшээлтэй хүний зам.....	23
10. Хөгжлийн бэрхшээлтэй хүний орон зай	23
11. Барилгын гадна орон зай, орц гарц.....	27
12. Олон нийт болон орон сууцны барилгын орон зайд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан төлөвлөлт	27
12.1 барилгын орц гарц.....	27
12.2 тэргэнцрийн налуу зам / дотор болон гадна /	28
12.3 хараагүй хүний хөтөч хавтан зам.....	33
12.4 хөтөч хавтан замын зохион байгуулалт	34
12.5 хонгил болон холбогч өрөө.....	35
12.6 хаалга /гадна, дотор/.....	36
12.7 гишгүүр шат	39
12.8 хана болон шатны бариулууд.....	40
12.9 цахилгаан шат	41
12.10 . Урсдаг шат	44
12.11 . Шүршүүр, душ	44
12.12 . Хувцас солих өрөөний орон зай	46
12.13 . Усанд орох онгоцны орон зай.....	47

12.14	. Гал тогооны өрөөний орон зай	48
12.15	. Зочны өрөөний орон зай	49
12.16	. Унтлагын өрөөний орон зай.....	50
12.17	. Нийтийн бие засах газар	52
12.18	. Халуун усны газар	54
12.19	. Ариун цэврийн өрөө	54
12.20	. Ариун цэврийн өрөөний тоноглол	56
12.21	. Угаалтуур болон толь.....	59
12.22	. Цонх.....	59
12.23	. Ундны усны цорго ба ус хөргөгч	60
13.	Эмнэлгийн барилгын өрөө тасалгааны орон зай.....	60
13.1	эдэлбэр газарт тавих шаардлага	61
13.2	эмчилгээний дасгалд зориулсан орон зайн байрлал	65
13.3	сүргүүлийн барилгын анги, танхим орон зайн төлөвлөлт.....	70
13.4	хүлээлгийн танхим, хүлээн авах	71
14.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тавилга, тоног төхөөрөмжүүдийн байршлын хэвийн хэмжээ.....	72
14.1	лангуу, тавиур, тавцан, шүүгээ.....	72
14.2	ширээ, тавиур	72
14.3	ширээ, тэргэнцрийн эзлэх орон зай	73
14.4	цахилгаан хэрэгслийн болон гэрлийн унтраагуур, залгуурууд.....	73
15.	Дохиоллын систем, таних тэмдэг	74
15.1	барилгын гадна орц гарцын дохиоллын тоноглол	75
15.2	харилцаа холбооны систем	76
15.3	олон нийтийн барилгад төлөвлөх харилцуур утас.....	77
15.4.	Гудамжинд байршуулах харилцуур утас	78
15.5.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний харах бүс	78
15.6.	Ил цухуйсан мөргөцгүүд	78
16.	Тэргэнцэртэй хүний суудал / үзвэрийн танхим /	79
17.	Сонсголын бэрхшээлтэй хүнд зориулсан суудал	81
18.	Таних тэмдгүүд, стандарт хэмжээ	82
19.	Олон улсын стандарт тэмдэг	82

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэд бүтцийн техникийн зураг төсөл

1. ЗОРИЛГО

Энэхүү баримт бичгийн зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудлаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, нийгмийн бүхий л харилцаанд бүрэн дүүрэн оролцох, ая тухтай амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх, тэдэнд ээлтэй нийгмийн дэд бүтцийн орчныг бүрдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

2. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү баримт бичиг нь орон сууц болон олон нийтийн барилгын гадна орчин, дотоод орон зайд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан төлөвлөлтийн зарим шаардлагыг тогтооход хамаарна.

3. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү баримт бичигт эш татсан доорхи баримт бичгүүдэд өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээрийн хамгийн сүүлийн албан ёсны хэвлэлээс хэрэглэнэ.

БНБД 31-101-04 Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль 2004 он

БД 31-112-11 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм 2011 он

БНБД 31-01-01 Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх норм ба дүрэм

БНБД 31-03-03*/11 Олон нийт, иргэний барилга

MNS 6055:2009 Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин

MNS 6808:2019 Явган хүний зам, талбайн төлөвлөлт, техникийн шаардлага

MNS 5611:2006 Орон сууцны барилгад тавигдах үндсэн шаардлага

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан акт (Americans with Disabilities Act /Access Guide: Survey Checklist/) 2010 он

4. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү баримт бичигт хэрэглэх нэр томьёог дараах утгаар ойлгоно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс – гэж урт хугацааны бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой бөгөөд энэ бэрхшээл нь орчны бусад хязгаарлалттай нэгдэн нийлж бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон хүмүүс

Хөгжлийн бэрхшээлтэй хүн – гэж эрүүл мэндийн хувьд төрөлхийн согогтой, биеийн үйл ажиллагаа, тэсвэр хатуужил муудаж доройтсон буюу өвчилсөн эсвэл бэртэж гэмтсэн, хөдөлмөрийн чадвараа бүрэн буюу хагас алдсан, амьдралын хүнд бэрхшээлд орсон хүн

Эргономик – гэж хүний хөдөлгөөн, орон зайнаас хамааруулан ажиллаж амьдрах, ая тухтай орчин бүрдүүлэх нөхцлийг судлах агуулгаар архитектурт хэрэглэгддэг нэр томьёо

Антопометр– гэж хүний бие, түүний хэсгүүдийн өөрчлөлтийн системийг заасан гол хэмжээ

Налуу зам– гэж босоо чиглэлд барилгын гадна дотно хэсгийг холбосон налуу хавтгай

Настай хүмүүс– гэж өндөр настай хүмүүсийн бүлэг

Тактильный– гэж хараагүй хүнд овгор, товгор байдлаар мэдрэгдэх тэмдэглэгээ

Бүсчлэл орон зай – гэж хэмжигдэхүүний тоон утга (урт, өргөн өндөр) орон зай болон байгуулалт дээр ямар нэг юмны хоорондох хязгаарлалтыг заасан хэмжээ. Жишээлбэл: хөгжлийн бэрхшээлтэй хүний эзлэх орон зайн өргөн, урт, тэргэнцэрийн эргэх радиус, хүрч болох өндрийн хэмжээ г.м

Брайлын үсэг – гэж хараагүй хүний тэмтэрч мэдрэхэд зориулагдсан товгор тэмдэглэгээ бичиг

Хөндлөн налуу – гэж явган хүний замын хөндлөн хэвгий

Замын хашлага – гэж явган хүний зам, ногоон байгууламжийг автомашины замаас тусгаарласан явган хүний зорчих чөлөөний хэсэг

Элемент – гэж ямарваа зүйлийг бүрдүүлэгч, язгуур хэсэг

Ревербераци – гэж дуу үүсгэгчийг зогсоосноос хойш дуу тархах хугацаа

5. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА


- 5.1. Энэхүү баримт бичиг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлогийг тусгайлан харгалзаж барилгын дотор орон зай, орчинд нэвтрэн орох, зорчих, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх, эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангахад мөрдөнө.
- 5.2. Баримт бичгийн үндсэн хэсэг нь тулгуур эрхтний гэмтэлтэй болон хараа, сонсголын бэрхшээлтэй хүмүүст зориулсан болно.
- 5.3. Баримт бичгийн шаардлагад сэтгэцийн хомсдолын хөнгөн хэлбэртэй, дотоод тархины гэмтэл, дотоод эрхтний өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон, мөн хэт өндөр настай, сул дорой биетэй хүмүүсийн хэрэгцээг тооцсон.
- 5.4. Сэтгэцийн өвчтэй, тусгай газар байх шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тавигдах шаардлага нь энэхүү баримт бичигт хамаарахгүй.

6. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ЭРГОНОМИК, АНТРОПОМЕТР


6.1. ТЭРГЭНЦРИЙН ЭЗЛЭХ ОРОН ЗАЙ

Хөдөлгөөний тоноглол хэрэглэдэг тахир дутуу хүмүүст хүрэлцэхүйц орон зай хуваарилагдсан байх ёстой. Жишээ нь: /тэргэнцэр, суга таяг хэрэглэх буюу бусдын тусламжтайгаар явж чадах хүмүүс/


Тэргэнцэртэй хүний гарын даяллыг тооцох хэрэгтэй. /урагшаа, хажуу тийш, дээш, доош г.м/ Тэргэнцрийн эргэх орон зайн хэмжээг тооцох ёстой.




Тэргэнцрийн эзлэх орон зай




Тэргэнцрийн эргэлт
хамгийн бага талбай




90° эргэхэд шаардагдах
хамгийн бага талбай




2 дугуйн төв дээр 180°
эргэхэд шаардагдах
хамгийн бага талбай




Шулуун өнцгөөр эргэхэд
шаардагдах хамгийн бага
муруй талбай



Нэг дугуй төв дээр 180°
эргэхэд шаардагдах
хамгийн бага талбай











Нэг дугуйн төв дээр 360° эргэхэд
шаардагдах хамгийн бага талбай



Тэргэнцрийн U хэлбэрээр эргэх орон зай


6.2. ТЭРГЭНЦРИЙН СТАНДАРТ ХЭМЖЭЭ




Гар жолоодлоготой тэргэнцэр

Автомат удирдлагатай тэргэнцэр


6.3. ТЭРГЭНЦЭРТЭЙ ХҮНИЙ ЕРӨНХИЙ ХЭМЖЭЭ, ЭРГОНОМИК



Тэргэнцэртэй хүний орон зайн гол хэмжээ




Тэргэнцэртэй хүний үйл хөдлөл хийх боломжтой хэмжээ




Тэргэнцэртэй хүний
энгийн зөрөх орон зай

Тэргэнцэртэй хүний
эзлэх цэвэр зай

Хажуу саадад
дөхөх цэвэр зай




Урдах саадад
тэргэнцэр
дөхөх цэвэр зай









$X < 610\text{мм}$ -ийн үе

дэх цэвэр зай



$X > 610\text{мм}$ -ийн үед

эргэх нэмэлт зай 150мм






Тэргэнцэр эргэх хамгийн бага диаметр


Тэргэнцрийн 180° эргэлт "Т" хэлбэрийн зай

Тэргэнцэртэй 2 хүн зөрөх хамгийн бага зай


6.4. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ АНТРОПОМЕТР



Суугаа байдлаар урагшаа гар сунгах үеийн өндрийн хэмжээ






$x < 635\text{мм}$ үед $z > x$ байж болно. $x < 510\text{мм}$ үед y -ийн хамгийн их утга 1220мм байна. $510\text{мм} < x < 635\text{мм}$ үед y -ийн хамгийн их утга 1120мм байна.



Саадтай хэсэг гар сунгах хамгийн их утга


Хажуу сааданд зэрэгцэн ойртох зай




Хажуу сааданд гараа өргөх, тонгойх зай

Саад дээгүүр гараа сунгах хамгийн их зай


Тэргэнцрийн зорчих өргөн




Тэргэнцэр ба хүний
хажуугын өргөн




Тэргэнцэр ба явган
хүний урдах өргөн




2 тэргэнцрийн
зэрэгцээ өргөн




Хос таягтай хүний явах өргөн



Таягтай хүний хажуугийн өргөн




Хос таягтай хүний урдах өргөн



Харагүйн таягтай хүний урдах өргөн

6.5. ТАЯГТАЙ ХҮНИЙ АНТРОПОМЕТР



Таягны төрлүүд

Хараагүй хүний таягтай явах орон зай

7. ХОТ СУУРИН ГАЗРЫН ОРОН ЗАЙД ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНД ЗОРИУЛСАН ТӨЛӨВЛӨЛТ

7.1 ЯВГАН ХҮНИЙ ГАРЦ, ЗАМ ТАЛБАЙ

Тэргэнцэртэй болон өндөр настай иргэнд зориулсан явган хүний замын налуу уртаашаа 5%, хөндлөн чиглэлд 1%-аас илүүгүй налуутай байна. Газрын гадаргын нөхцөлөөс хамаарч заагдсан хязгаарыг баримтлах боломжгүй бол 12м-ээс багагүй урттай замын налууг 10%-аар нэмж болно. Гэхдээ уруудах замын дунд хэсэгт тэгш талбай төлөвлөнө.



Явган хүний зам болон авто тээврийн хэрэгсэл зорчих замын огтлолцлын өндрийн зөрүү 4см-ээс ихгүй, 2см-ээс багагүй байна. Замын гарцад хурц үзүүртэй хашлага, чулуу

хэрэглэх мөн хөдөлгөөний хэсгийн өргөнийг нарийсгахыг хориглоно. Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихтэй хэсэгт хаалт төлөвлөнө.

Авто тээврийн хэрэгсэл зорчих зам дахь зурвас газрыг дайран өнгөрөх явган хүний замын өргөн 3м, урт нь 2м-ээс багагүй байна.


Орон сууцны бичил хороололд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулан явган хүний замын дагуу 300м тутамд сандал төлөвлөнө.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг болзошгүй аюултай хэсгээс хамгаалах зорилгоор 5см-ээс багагүй өдөртэй чулуун хашлагаар тухайн хэсгийг хашиж өгнө.

Ослын үед хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг нүүлгэн шилжүүлэх гарцыг чөлөөтэй орж гарахаар төлөвлөнө.

7.2 ЯВГАН ХҮНИЙ ЗАМ


Явган хүний зам, налуу зам /пандус/-ын гадаргууг хэт товгор, гүдгэр материалаар хийхийг хориглоно. Харин бетон хавтангаар хийх бол гадаргуу нь тэгш, хавтангийн хоорондын зай 1.5м-ээс ихгүй байна.





Хивсэнцэр дэвссэн замын уулзвар хэсэг болон захын ирмэг хэсгийг сайтар бэхэлсэн байна. Хивсэнцрийн зузаан 1.3см-ээс ихгүй байна.

Харааны бэрхшээлтэй иргэнд зориулсан тоглоомын болон бэлтгэл сургуулилт хийх биеийн тамирын заалны шалны гадаргуу тэгш байна.

Явган хүний зам дээр тавигдсан сааралжин тагийг хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлгөөний чиглэлд эгц байрлалтай, сараалжийн хоорондын зай 1.3см-ээс ихгүй байна.





Замын хавтан хоорондын зай 10мм-ээс ихгүй

Гарцын налуу замын загвар

7.3 АВТО МАШИНЫ ЗОГСООЛ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан авто зогсоолыг орон сууц, олон нийтийн барилга байгууламж, ажлын байр хүртэлх 50м-ээс ихгүй зайд төлөвлөнө.


Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчлэх нийтийн тээврийн зогсоолын талбай олон нийтийн барилга байгууламжаас 100м-т, тэдгээрийн амьдрах орон сууцны барилга байгууламжаас 300м-т байхаар тооцно.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувийн авто тээврийн хэрэгсэл зогсох зогсоолын талбайг тусгайлан тэмдэглэж таних тэмдгээр заасан байна. Зогсоолын өргөн 3.5м-ээс багагүй байна.


Зураг 1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний авто зогсоолын загвар




Тэмдэг заалт бүхий зогсоол нь тахир дутуу хүмүүст зориулсан тахир дутуу хүмүүсийн захиалгат талбай болно.




Зогсоолын хэмжээ



Зогсоолын таних тэмдэг






8. НИЙТИЙН ТЭЭВРИЙН ЗОГСООЛ


Явган хүний зам дээр хараа муутай хүмүүст зориулсан 2 эгнээ хөтөч хавтанцар замыг буудлын саравчны баганаас 300мм-ээс багагүй зайд бэлтгэж тавина.

Буудлын саравчны багана харанхуй болоход тодорхой харагдахуйц байх.


Автобусны буудал нь / зогсоол / суух вандан, саравчаар тоноглогдсон, автобусны явах чиглэлийн тэмдэглэгээ бүхий шон байрлуулсан байна.



1-р зэрэглэлийн зогсоолын зай хэмжээ




2-р зэрэглэлийн зогсоолын зай хэмжээ







3-р зэрэглэлийн зогсоолын зай хэмжээ

Зураг 2. Автобусны буудлын харагдах байдал /жишээ/



Зураг 3. Автобусны буудлын харагдах байдал /жишээ/







8.1 НИЙТИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ДОТООД ОРОН ЗАЙ, ТОНОГЛОЛ

Хаалга

- Автобусны хаалга тэргэнцэр орохуйц өргөнтэй байх ёстой /900мм-ээс багагүй/.
- Намхан гишгүүр суурилуулсан байх.
- Хаалга, шатны бариул болон автобусны шал зэргийг халтирдаггүй материалаар хийх ёстой.
- Тэргэнцрийн зориулсан өргөгч шалыг автобусны хаалганы хэсэгт суурилсан байх.

Тэргэнцрийн зай

- Бусад зорчигчдын бууж суухад нь саад болохгүйгээр тохирсон байрлалтай байх.
- Уг байрлалыг автобусны гадна, дотор талд байрлуулсан “тэргэнцэр” гэсэн стандарт таних тэмдэг заана.
- Тэргэнцрийн дугуй тогтоогч болон аюулгүйн бүсээр хангагдсан байх.

Суудал


- Автобусанд хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настанд зориулсан суудал хаалганы ойр 2 ширхэг байх ёстой.

Буух дохио

- Сууж байгаа болон зогсож байгаа зорчигчид хялбар хүрч болохуйц байрлалтай хэд хэдэн буух дохионы товчлуур төлөвлөгдсөн байна.
- Дарах товчлуур нь тод харагдах зайнд байх.

Мэдээллийн тэмдэг

- Зогсоолуудыг чанга яригчаар мэдээлж байх / чиглэлийн дагуу /.
- Автобусны урд болон хажуу талд явах чиглэлийг томоор тодорхой бичсэн байх ба харанхуйд гэрэлтэж харагдах байвал бүр сайн.



8.2 ГАЛТ ТЭРЭГ

Метро, галт тэрэг

- Галт тэрэгний хаалга тэргэнцэр орох хүрэлцэхүйц зайтай байх.
- Галт тэрэгний хаалга тавцангийн хоорондох заадас хамгийн доод /бага/ хэмжээнд байх ёстой.

Эгнээ хоорондын зай

- Эгнээ хоорондуур тэргэнцэртэй хүн чөлөөтэй явах өргөнтэй байх

Тэргэнцрийн зай

- Энэ зай нь хаалга талд чөлөөтэй байх.
- Зайг галт тэрэгний гадна дотор талд байрлуулсан /бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн/ таних тэмдгээр заана.

- Тэргэнцэртэй хүмүүсийн барих бариул, бүс оосор болон бусад хэрэгслийг суурилуулсан байна.

Суудал

- Хаалганы ойр хөгжлийн бэрхшээлтэй хүн, өндөр настай хүнд зориулсан тусгай суудлыг төлөвлөх.


Мэдээллийн тэмдэг болон зардал

- Галт тэрэгний чиглэлийг заасан схем зургийг байрлуулсан байх.
- Чиглэлийн дагуух зогсоолуудыг чанга яригчаар зарлах ба буудлуудын нэрийг бичсэн үзүүлэн харагдахуйц зайнд байх.



Зураг 4. Зорчигч буулгаж суулгах тусгай хэрэгцээний тавцан




9. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЗАМ



Тэргэнцэртэй хүний энгийн зөрөх орон зай Тэргэнцэртэй 2 хүн зөрөх хамгийн бага зай



Нүхний хэмжээ 13мм-ээс ихгүй Тэргэнцрийн явах чигт 90°-ын чиглэлээр торыг тавина



Борооны ус зайлуулах сараалж / 20тн хүртэлх ачааллыг даана /

10. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ОРОН ЗАЙ

Тэргэнцэртэй иргэнд зориулсан талбайн өргөн 0.9м, урт нь 1.5м-ээс багагүй байна.


Тэргэнцэртэй иргэний зорчих замын өргөн нэг талын хөдөлгөөнтэй үед 1.2м-ээс багагүй, хоёр талын хөдөлгөөнтэй үед 1.8м-ээс багагүй байна.

Нэвтрэх хаалганы өндөр 2.1м-ээс багагүй байна.


Тэргэнцрийг 90 градус эргүүлэх талбай 1.3х1.4м, 180 градуст 1.3х1.7м, 360 градуст 1.5х1.7м-ээс багагүй байна. Тэргэнцэртэй хүний ашиглахад тохиромжтой тоног төхөөрөмж, шүүгээний өргөн 0.6м-ээс багагүй, өндөр нь шал болон явган хүний замын түшингээс

0.6м-ээс багагүй байна. Тоног төхөөрөмж, тавилга руу очих замын өргөн 0.9м-ээс багагүй, тэргэнцэртэй 90 градуст эргэх тохиолдолд 1.2м-ээс багагүй талбайтай байна.


Барилга байгууламжийн хананд байрлуулсан шуудангийн хайрцаг, харилцах утасны мэдээллийн самбар, зарын самбар гэх мэт тоног төхөөрөмж нь хөгжлийн бэрхшээлтэй болон тэргэнцэртэй иргэний явах, эргэлт хийх зам, талбайд саад болохооргүй байна.




Амрах хэсгийн хялбар зай




Ширээ, суудлын хэсгийн хамгийн бага орон зай




Тэргэнцэртэй 2 хүн зэрэгцэн зорчих орон зайн хамгийн бага хэмжээ




90°-ын налуу эргэлтийн доод хэмжээ




Хаалтыг тойрох зайн хэмжээ




Супермаркетын гарцын зорчих өргөн




Супермаркетын коридорын зорчих өргөн




Худалдааны төвийн коридорын зорчих өргөн







Тасалбар таслах коридорын зорчих өргөн




Хаалтын өргөн



Тэргэнцэртэй 2 хүн зөрөх



11. БАРИЛГЫН ГАДНА ОРОН ЗАЙ, ОРЦ ГАРЦ



12. ОЛОН НИЙТ БОЛОН ОРОН СУУЦНЫ БАРИЛГЫН ОРОН ЗАЙД ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНД ЗОРИУЛСАН ТӨЛӨВЛӨЛТ

12.1 БАРИЛГЫН ОРЦ ГАРЦ

Иргэний зориулалттай /орон сууц, олон нийт/ барилгад хөгжлийн бэрхшээлтэй хүний орох боломжийг хангасан налуу зам болон бусад тоног төхөөрөмжүүд /орох түвшин хүртэл хэрэглэх өргүүр/-ээр заавал тоноглогсон байна.

Тухайн барилгын орцын шийдэл, орц хаалганы байрлал, орчны тодорхой байдлаас хамааруулж тэргэнцэртэй хүний эргэлтийн хөдөлгөөн хийхэд зориулсан хувилбарыг хавсралтад зааснаар сонгоно. Өгөгдсөн талбайн ерөнхий хэмжээ нь зөвхөн орцын хаалганы төрөл ба түүний онгойх чиглэлээс бус хаалгаруу дөхөх үндсэн чиглэлээс хамаарч тодорхойлно.


Барилгын орцын өмнөх талбай, налуу зам, шат нь өөрийн орны цаг уурын нөхцөлтэй уялдан хатуу гадаргуун хучилттай, халаах тоноглолтой, мөн /өргөх төхөөрөмжүүд зэрэг нь/ хур тунадаснаас хамгаалсан байна.

Хаалганы онгойх чиглэл ба байршлаас хамаарч гонхны /тамбур/ ерөнхий хэмжээ нь хавсралтад заасан хэмжээнээс багагүй байна.

Барилга, өрөө тасалгааны гол хаалга нь хөгжлийн бэрхшээлтэй хүн ашиглах боломжтой 850мм-ээс багагүй өргөнтэй, орон зай нь уужим цэлгэр байна. Хаалганд хэрэглэсэн нугас, эргэх хөдөлгөөний тоноглолуудыг хамааруулж үзэхгүй. Хаалгыг хаах онгойлгох байрлалд түүнийг тогтоох тусгай хэрэглэлүүдээр тоноглож болно. Хаалга нь автоматаар онгойж, дэлгэгддэг, эсвэл хавтастай байж болно. Автоматаар онгойдог шилэн хаалгыг төлөвлөхөд шалнаас 1500мм-ийн өндөрт тод өнгөөр тэмдэглэгээ тавьсан байна. Барилгын орц, өрөө тасалгааны хаалга нь хөгжлийн бэрхшээлтэй хүн зорчиход зориулж босгогүй байх ба хэрэв босготой бол өндөр нь 25мм-ээс илүүгүй байна.

Орцын хаалганы хавтсанд доргилт, цохилтод тэсвэртэй шилэн хавтасны доод ирмэг шалны түвшнээс 900мм-ээс ихгүй өндөрт байхаар суулгаж өгнө. Хаалганы шилэн хавтсыг дундаа төмөр тортой /арматуртай/, эсвэл хатуулаг шилээр хийнэ. Хаалганы хавтасны доод хэсэг нь цохилт доргилтоос хамгаалж 300мм-ийн өндөртэй хамгаалах бүстэй байна. Хаалганы бариулын гадаргуу нь гар хүрэхэд эвтэй, гарын хуруу буюу шууны хөдөлгөөнөөр хөнгөхөн онгойдог, хаалгыг онгойлгож хаах үеийн дээд хүч нь 2.5кг-аас ихгүй байна.

Хараагүй хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан хаалга нь ашиглах үеийн аюулгүй байдлыг хангасан, чиглэл /байрлал/-ийг хөнгөвчилсөн байдлаар тоноглогдсон байх ёстой. Хаалганы байрлал, өрөө тасалгааны зориулалт, хаалганы онгойх чиглэл, тэмдэглэгээний байрлал зэргийг мэдээлэх зохистой систем болох дуу авиа үүсгэгч, тод харагдахуйц бичиглэлээр тоноглоно. Шилэн хавтастай хаалгыг ашиглах үед ханан дээр шалны түвшнээс 1600мм-ийн өндөрт 150мм-ийн өргөнтэй сэрэмжлүүлэх өнгөт зурвасыг хэвтээ чиглэлд зурж тэмдэглэнэ. Орох, гарах хаалганы хавтсыг өөр өөр өнгүүдээр ялгаж өгнө. Орох хаалганы баруун гар талд 1000-1100мм-ийн өндөрт өрөөнүүдийн болон барилгын дугаарыг ялтсан дээр товойлгон дүрсэлж /кирилл тоогоор/, бэхэлсэн байна.



12.2 ТЭРГЭНЦРИЙН НАЛУУ ЗАМ / ДОТОР БОЛОН ГАДНА /

Явган хүний зам, талбайн түвшин барилга байгууламжийн шалны хоорондох уналтын зөрүү 4см-ээс их бол налуу зам эсвэл шат төлөвлөнө. Налуу замын бүтээц, тэдгээрийн хаалт хамгаалалтыг галд тэсвэртэй материалаар хийж, гал тэсвэрлэлтийн хязгаар 2

цагаас багагүй байна. Дугуй хэлбэрийн налуу зам төлөвлөхийг зөвшөөрөх бөгөөд дотор радиусын хэмжээг хавсралт 2-т тооцсоны дагуу авна. Дугуй хэлбэртэй налуу замын засвар хоорондын талбайн урт түүний радиусаас хамаарч 2м-ээс багагүй байна.





Налуу замын өгсөлт бүрийн эхлэл төгсгөл дээр тэгш талбайг төлөвлөх ба өргөн нь налуу замын өргөнөөс багагүй, урт нь 1.5м-ээс багагүй байна. Налуу замын чиглэлийг өөрчлөх тохиолдолд тэгш талбай нь өргөн дугуйт тэргэнцэр эргэхэд саадгүй байна.

Налуу зам, тэгш талбайн захаар 5см-ээс багагүй өндөртэй хашлага хийх шаардлагатай.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний явах чигийн дагуу шатны гишгүүр нягт, тэгш, тээглэх зүйлгүй, гадаргуу нь бага зэрэг барзгар байна. Гишгүүрийн ирмэг 5см-ээс багагүй дугуйралтай байна. Шатны гишгүүрийн захаар 2 мм-ээс багагүй хашлага байна. Гадна шатны гишгүүрийн өргөн 40см-ээс багагүй, барилгын дотор шатны гишгүүрийн өргөн 30см-ээс багагүй, гишгүүрийн өндөр гадна шатанд 12см, дотор шатанд 15см-ээс ихгүй байна.



Налуу замын 2 талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон бусад хүмүүс барихад зориулагдсан хаалтын бариулын дээд ирмэг хүртэл өндөр 0.7-0.9м-ээс багагүй, сургуулийн өмнөх насны хүүхдэд бариулын өндөр 0.5м байна. Налуу замын эхлэл төгсгөлд бариулыг 0.3м-ээс ихгүй илүү гаргаж төгсгөнө. Бариулын хөндлөн огтлолын диаметр 3см-ээс багагүй 5см-ээс ихгүй, хөндлөн огтлолоор зузаан нь 0.04м-ээс ихгүй байна.

Хоёр болон түүнээс дээш давхраас аврах зориулалттай налуу замыг барилга байгууламжаас гадагшаа гарах хаалгатай шууд холбосон байна.




Хамгаалалтын хашлагийн хөндлөн огтлол


Бариулын загвар ба онцлог



Налуу замтай хаалганы орон зай




Нэг урсгалтай налуу зам






Хоёр урсгалтай налуу зам






Нэг урсгалтай урт налуу зам / дээрээс, хажуугаас харсан байдал /







Барилга доторх ба гаднах пандусын хамгийн бага хэмжээ



Налуу хэсгийн хамгаалалт



Пандусын амрах хэсгийн хамгийн бага хэмжээ



12.3 ХАРААГҮЙ ХҮНИЙ ХӨТӨЧ ХАВТАН ЗАМ



Цэг маягийн хээтэй хавтанцууд нь сэрэмжлүүлэх дохио өгдөг. Эдгээр нь саад бартаанаас хамгаалах, унах болон бусад аюул осол, буруу чиглэлийг хорих, өнцөг булан, уулзварыг сануулна.

Шугаман хэлбэрийн хээтэй хавтанцууд нь дагаж явах чиглэлийг заана.



Хөтөч хавтанцуудыг байрлуулах газрууд:

- Замын хөдөлгөөн байгаа хэсгийн өмнө
- Орц, гарцын өмнө, шатны эхлэл, төгсгөлд олон түвшинтэй газруудад
- Нийтийн тээврийн буудлуудын орох, гарах, суух, буух хэсэгт
- Замаас барилга руу хүрэх чиглэлд
- Нийтийн үйлчилгээний газраас ойр орших нийтийн тээврийн зогсоол руу явах чиглэлд
- Хөдөө, суурин газарт

Энд олон нийтийн газар хүрэх замыг тусгаарлах зорилгоор янз бүрийн хэлбэр, өнгөтэй чулуугаар хашлагыг нь хийнэ.




Шулуун явах хэсгийн хавтан




Уулзварын хэсгийн хавтан


12.4 ХӨТӨЧ ХАВТАН ЗАМЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ




Хараа муутай хүмүүст зориулсан хөтөч явган замын уулзварын зохион байгуулалт




Уулзварын хавтангийн төрлүүд



Цахилгаан шат, товчлуурын өмнөх хөтөч



Шатны өмнөх хөтөч



Автомат хаалганы өмнөх хөтөч хавтан


12.5 ХОНГИЛ БОЛОН ХОЛБОГЧ ӨРӨӨ

Хонгил болон туслах өрөө нь тэргэнцэр явахад зориулж хангалттай өргөн байх ёстой.


Хэрвээ хонгилын өргөн 1500мм-ээс / эргэлтийн доод цэвэр хэмжээ / бага байвал, эргэлтийн зайг өөр боломжтой газар байрлуулна.

Холбогч өрөө болон хонгилын гадаргуу нь “Хялбарчилсан замын давхарга”-ын зааварт нийцсэн байх.


Гол зай ба ил гарсан мөргөцгүүд нь “Ил цухуйсан мөргөцгүүд”-ийн зааварт нийцсэн байх ёстой.



Тэргэнцэр 180° эргэх үед



Хаалганы өмнө тэргэнцэр эргэхэд зориулж 140см гүн байна



12.6 ХААЛГА /ГАДНА, ДОТОР/

Үүд хаалга нь тэргэнцэртэй хүн чөлөөтэй орохуйц өргөнтэй байх ёстой /цэвэр онгойлт доод тал нь 815мм-ээс багагүй байна/.

Хаалганы өмнө тэргэнцэртэй хүн эргэлт хийх, хаалга онгойход тэргэнцэр тулахааргүй хэмжээний зай байх ёстой.

Хаалганы босго 20мм-ээс хэтэрч болохгүй. Үүнээс өндөр босго, шалны түвшинтэй өөрчлөлт гарвал 2 талаас нь налуу болгож болно.


Хаалгыг нээх, хаах бариул, татагч болон бусад хэрэгслүүд нь хүч чадал муутай хүмүүс барихад хялбар хэлбэртэй, тохирсон өндөртэй байх ёстой.

Хөшдөг бариул болон түлхэх маягийн механизм хийхийг санал болгож байна.


Хараа муутай хүмүүст зориулж хаалгыг орчны элементүүд /хана, тааз, шал г.м/-ээс тод өнгөөр ялгах нь ашигтай.

Шилэн хаалга нь нүдний түвшинд хурц өнгийн хээтэй байх ёстой.


Эргэдэг хаалгатай газар тэргэнцэр орж болохуйц өөр хаалга төлөвлөнө.




Урагш дөхөж хаалга дэлгэх орон зай



Хажуугаас дөхөж хаалга дэлгэх орон зай





хаалга хаагчтай
бол $Y=1370\text{мм}$
байна






Түгжээний талаас дөхөх орон зай

Түгжээний талаас дөхөж хаалга дэлгэх орон



Гулсдаг хаалганд эгц чиглэлд дөхөх орон зай


Гулсах талаас дөхөх орон зай




Хаалга түгжигчтэй бол
 $X=300\text{мм}$ байна

Хаалга түгжээ болон хаагчтай бол
 $Y=1220\text{мм}$ -ээс багагүй байна

Хаалга хаагчтай бол
 $Y=1220\text{мм}$ байна




Давхар хаалганы дэлгэгдэх орон зай




Хаалганы хамгийн бага хэмжээ

12.7 ГИШГҮҮР ШАТ


- Шатны цуваа нэг хэвийн, жигд байна.
- Шатны цуваа налуу огцом биш байх.
- Шатны бариул нь 2 талдаа бат бэх суурилагдсан байна.
- Шатны бариул нь гишгүүрээс дээш тохирсон өндөрт, барихад эвтэйхэн байх.
- Шатны бариул дээд, доод төгсгөлдөө шатнаас илүү гарсан байх.
- Тавцангийн хооронд цувааны өгсүүр нь тохирсон өндөртэй байх.
- Шатны завсар хоорондын тавцан нь цувааны өргөнтэй адил байх.
- Шатны бариулын бусад шаардлагуудыг “шатны бариулын” заавраас мөрдөж болно.
- Гишгүүрийн нэмэлт шаардлагуудыг “Талбай, шалны гадаргуу”-гийн заавраас харж болно.
- Шатны ирмэг нь хурц, тод өнгөөр ялгагдсан байна.
- Шатны хонгил нь хангалттай гэрэлтүүлэгтэй байна.



/ гулгахаас хамгаалсан зөөлөвч хийх /




/ бариуланд хараагүй хүний тэмдэглэгээ хийх /



Гишгүүрийн загвар



Бариултай шатны хөндлөн огтлол



Үргэлжилсэн бариултай болон хэсэгчилсэн бариултай шат


12.8 ХАНА БОЛОН ШАТНЫ БАРИУЛУУД

Шатны бариул нь өргөн голчтой бат бөх байвал барихад амар, тулгуур сайтай байна.

Шатны барьц бариул нь ханатай зэрэгцэн тогтоогдсон бол хана, бариулын хооронд зайтай байх ёстой.


Барьц бариулууд нь ханын хөндийд тогтоогдсон бол ханын хөндийн дээд доод хэсгийн налуугийн өндөр тооцогдсон байх ёстой.


Шатны бариулуудын өнгө нь орчноосоо тод, хурц өнгөөр ялгаатай байх ёстой.



Хонгил болон шатны бариулууд


Шатны хана талын бариул






12.9 ЦАХИЛГААН ШАТ


Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орж гарах өрөө тасалгаа 1 дүгээр давхраас дээш байх бол тухайн барилгад цахилгаан шат төлөвлөх ба хүн тээвэрлэх бүхээгийн өргөн 1.1м, гүн 1.5м, хаалганы өргөн 0.85м-ээс багагүй байна. Цахилгаан шат нь давхрын түшингээс болон бүхээгээс удирдах удирдлагатай байх ба гудамж руу шууд гарах гарцтай байна.



Лифтний тэмдэглэгээ
ба хэмжээ




Лифтний хаалга болон
бүхээгийн хэмжээ




Лифтний товчлуурын
загвар хэмжээ

Цахилгаан шатны гарах гарцыг 1 дүгээр давхарт үүдний хонгил болон хөлийн өрөө рүү шууд гарахаар төлөвлөнө. Цахилгаан шатны хонгил нь галд тэсвэртэй тусгаарлагч хана ба хаалгаар зааглагдсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан цахилгаан шатны хонгилыг шат хоорондын талбайд төлөвлөхийг хориглоно.


Цахилгаан шатны шал, барилгын шалны хоорондын түвшний зөрүү 2.5см-ээс ихгүй байна.




Тэргэнцрийн ухарч
орох, гарах загвар




180° градус эргэх
оломжтой бүхээг




Цахилгаан тэргэнцрийн
эргэх загвар ба бүхээг




Лифтний дотор талын
барил, товчлуурын хэмжээ



Хэвтээ чиглэлийн
өргөгч тавцан




Босоо чиглэлийн
өргөгч тавцан



Өргөгч тавцангийн загвар ба хэмжээ

12.10. УРСДАГ ШАТ



12.11. ШҮРШҮҮР, ДУШ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан шүршүүрийн бүхээгийн төлөвлөлт нь шүршүүрт орох, шүршүүрийн суудалд суух зэрэгт саадгүй байх шаардлагатай.

Шүршүүр нь тэргэнцэртэй хүн амархан дамжиж сууж болохуйц хялбарчилсан өндөр, өргөнтэй байх.


Мөн тэргэнцэртэй хүн төвөггүй барьж болох бариултай /байрлал, өндөр нь тохирсон/ байх хэрэгтэй.

Аюул ослын үед төвөггүй хүрч болох дуудлагын товчлуур буюу дохиоллын тусгай төхөөрөмжөөр тоноглогсон байх.


Тэргэнцэртэй хүн шилжих хөдөлгөөн хийх /суух, буух/ хангалттай орон зайг шүршүүрийн онгоцны хажууд гаргах.

Шүршүүрийн өрөөний хаалга нь гулсдаг эсвэл гадагшаа онгойдог байхаар төлөвлөнө.


Эдгээр зөвлөмж нь бага орлоготой айл өрхөд зориулсан нийтийн халуун усны орон зайг тоноглоход хамаатай.






915x915 хэмжээтэй шүршүүр







915x1220 хэмжээтэй шүршүүр



12.12. ХУВЦАС СОЛИХ ӨРӨӨНИЙ ОРОН ЗАЙ



12.13. УСАНД ОРОХ ОНГОЦНЫ ОРОН ЗАЙ



12.14. ГАЛ ТОГООНЫ ӨРӨӨНИЙ ОРОН ЗАЙ

Гал тогооны өрөөний гал нь халтирдаггүй материалаар хийгдсэн байх ёстой.

Ажлын ширээ, цахилгаан зуухны ширэм нь тэргэнцэртэй хүн ажиллахад тохиромжтой ижил түвшинд байх.





Угаалтуур, ажлын ширээн доогуур тэргэнцэртэй хүний өвдөг орох зай хангалттай байх.

Ширээ, угаалтуур, зуухны хооронд хөдөлгөөн хийх хангалтай зай байх ёстой.


Цорго нь холимог байх ба хөшүүргэн хаагч бариултай байх.


Гал тогооны тоног төхөөрөмжүүдийн хянах товчлуурууд нь хэрэгслийнхээ нүүрэн талд байх ба янз бүрийн эмгэгтэй хүмүүс аюулгүйгээр удирдан ажиллуулж чадах хэмжээнд байх.

Зуухны таг нь доошоо чиглэлд онгойдог байвал тохиромжтой.



12.15. ЗОЧНЫ ӨРӨӨНИЙ ОРОН ЗАЙ






12.16. УНТЛАГЫН ӨРӨӨНИЙ ОРОН ЗАЙ



Унтлагын өрөөний орны эргэн тойронд тэргэнцэртэй хүн явах хүрэлцэхүйц зайтай байх.


Орны орчин орон зай нь тэргэнцэртэй хүн шилжиж хөдөлгөөн /дамжиж суух/ хийх, туслах хүн үйлчлэхэд хүрэлцэхүйц хэмжээтэй байх.

Орны хэвтэх хэсгийн өндөр нь тэргэнцрээс шилжихэд төвөггүй хэмжээнд /ижил түвшинд/ байх.

Орны хажуугийн ширээ нь хэвтэж буй хүн хүрч болох тохирсон өндөртэй байх ёстой.







12.17. НИЙТИЙН БИЕ ЗАСАХ ГАЗАР

Олон нийтийн барилгын ариун цэврийн өрөөнд тэргэнцэр болон бусад хэрэгсэл ашиглах хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан ариун цэврийн өрөөг төлөвлөнө. Ариун цэврийн өрөөний өргөн 1.65м, урт нь 1.8м, хаалганы өргөн 0.9м-ээс багагүй ба босгогүй байна.

Тэргэнцрээс бие засах суултуурын нэг талаас шилжин суух хангалттай зайтай байна.

Таяг болон бусад хэрэгсэл ашиглаж явдаг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд нийтийн ариун цэврийн өрөөний нэгээс багагүйд нь хажуугийн хананд бариул байрлуулна.

Ариун цэврийн өрөөний бие засах газарт 1 хөтөвчийг шалнаас 0.4м-ээс ихгүй өндөрт, 2 талд нь босоо тулгуур бариул хийж өгнө.





Нийтийн ариун цэврийн өрөөний 1 угаалтуурыг шалны төвшнөөс дээш 0.8м-ээс ихгүй өндөрт, хажуугийн хананаас 0.2м-ээс багагүй зайд байрлуулна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан толь ба гар хатаагчийг шалны түвшнээс дээш 0.8м-ээс ихгүй өндөрт байрлуулна.

Нийтийн халуун усны газарт тэргэнцэртэй иргэнд зориулж нэг өрөөг төлөвлөнө. Шүршүүрийн бүхээгийн хэмжээ 1.2х0.9м-ээс багагүй байна. Бүхээгийн өмнөх зайг тэргэнцэртэй иргэн орохоор тооцно.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан шүршүүрийн бүхээгийн төлөвлөлт нь шүршүүрт орох, шүршүүрийн суудалд суух зэрэгт саадгүй байх шаардлагатай.



Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ариун цэврийн өрөө, бусад өрөөний хаалгыг гадагшаа онгойхоор төлөвлөнө.

Орон сууцны угаалгын өрөөний өргөн 1.2м, урт нь 1.6м-ээс багагүй байна.



12.18. ХАЛУУН УСНЫ ГАЗАР

Нийтийн халуун усны газарт тэргэнцэртэй иргэнд зориулж нэг өрөөг төлөвлөнө. Шүршүүрийн бүхээгийн хэмжээ 1.2х0.9м-ээс багагүй байна. Бүхээгийн өмнөх зайг тэргэнцэртэй иргэн орохоор тооцно.



12.19. АРИУН ЦЭВРИЙН ӨРӨӨ

Бие засах газар нь тэргэнцэртэй хэрэглэгчид орох, гарах хангалттай зайтай байх ёстой.

Суултуур нь тэргэнцэртэй хүмүүс төвөггүй хүрэх байрлалтай байх.

Суултуурын өндөр нь тэргэнцэр хэрэглэгчдэд тохирсон өндөртэй байх ёстой.

Бие засах газрын тасалгаанууд нь байрлал, өндрөөрөө тэргэнцэртэй хүмүүст болон бие эрхтний бусад эмгэгтэй хүмүүст тохирсон байх хэрэгтэй.


Бие засах газрын ариун цэврийн цаасны төхөөрөмж нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хялбар авч болохоор суурилагдсан байх.



Савангийн тавиур, цахилгаан гар хатаагч болон толь зэрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ая тухтай хэрэглэж болохуйцаар байршигдсан байх.

Крантны байрлал нь тэргэнцэртэй хүнд тохирсон байх.

Шал нь халтирдаггүй материалаар хийгдсэн байх ёстой.


Хаалга нь гулсдаг эсвэл гадагш онгойдог байх.

















Ариун цэврийн өрөөний хэвийн хэмжээ

12.20. АРИУН ЦЭВРИЙН ӨРӨӨНИЙ ТОНОГЛОЛ








Ус татах хөл товч хэлбэр

Ус татах гар товчны таних тэмдэг




12.21. УГААЛТУУР БОЛОН ТОЛЬ

Угаалтуурыг тэргэнцэртэй хүн ашиглаж болох өндөрт байршуулсан, хөдөлгөөн хийхэд саадгүй зайд суурилуулах.

Угаалтуурын доогуурх зай нь тэргэнцэртэй хүний өвдөг хлө орж байрлахад тохирсон байх.

Толь тэргэнцэртэй хүн харж болохуйц байх.




12.22. ЦОНХ


Цонх нь тэргэнцэртэй хүрэх бололцоо бүхий зориулалттай байх.

Тэргэнцэртэй хүн орчныг саадгүй харах бололцоог тооцон цонхыг байршуулах.


Цонхны хөшиг болон хаалтын татлага нь тэргэнцэртэй хүн хүрч болохоор байх.



12.23. УНДНЫ УСНЫ ЦОРГО БА УС ХӨРГӨГЧ



Ширээ болон усны цоргын өндөр, гүн



Ширээ болон усны цоргын өндөр, гүн

Ус хөргөгч

13. ЭМНЭЛГИЙН БАРИЛГЫН ӨРӨӨ ТАСАЛГААНЫ ОРОН ЗАЙ

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан эмнэлгийн барилгын төлөвлөлтийг тусгай БНБД-г баримтлан гүйцэтгэнэ.

Бусад бүх төрлийн эмнэлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулж доорхи арга хэмжээг авна. Үүнд:

- Хэвтэх өрөөг ариун цэврийн өрөөтэй цуг төлөвлөнө. Төлөвлөлтийг боловсруулахдаа уг гарын авлагыг 3.8, 3.8.1, 2, 3.9.1, 2-ын заалтыг мөрдөнө.
- Хэвтэх тасгын өрөөнд тэргэнцэр эргэх зориулалтаар Ø1500мм-ийн сул орон зай төлөвлөнө.
- Хаалгыг тэргэнцэртэй хүн чөлөөтэй нэвтрэх өргөнтэй төлөвлөнө.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүн хэвтэх өрөөг 1-2 давхарт байршуулан төлөвлөх ба цахилгаан шат, налуу зам, барилгын гарц, орц, галын аюулаас хамгаалах шатанд хамгийн ойр зайд байна.

- Эмнэлгийн гадна орц, гарцанд тэргэнцрийн зам, хөтөч хавтанцран замыг төлөвлөнө. Төлөвлөлтийн нэмэлт шаардлагыг тусгах бол хөгжлийн бэрхшээлтэй хүний эргономикийн заалт 1.2.2, 3, 4, 5, 6, 7, 1.3.1, 2, 3-ыг мөрдлөг болгоно.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настан, бага насны хүүхэдтэй хүмүүст зориулсан үйлчилгээнүүдийн дотроос хамгийн чухал нь эмнэлгийн үйлчилгээ юм.

Эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхэд архитектурын орчин нь хөгжлийн бэрхшээлтэй хүний бие сэтгэл зүйн байдалд энэрэнгүй талаасаа илүү нөлөө үзүүлж байх ёстой.

Энэ агуулгаар хөгжлийн бэрхшээлтэй болон хөдөлгөөн хязгаарлагдмал хүмүүст дээд зэргийн үйлчилгээ үзүүлэх боломжийг хангахын тулд барилга дахь саад тотгоруудыг арилгаж зайлуулах чиглэлээр төлөвлөлтийн арга хэмжээ авна.

Эмнэлэг-урьдчилан сэргийлэх байгууламжуудын дотроос хөдөлгөөн хязгаарлагдмал хүмүүст илүү ойр үйлчилгээ үзүүлэх зориулалттай барилга нь нэгдсэн эмнэлэг, явуут үйлчлэх эмнэлэг, эмийн сан юм. Эдгээр нь хүмүүст эмнэлгээс гадуур нарийн мэргэжлийн тусламж үзүүлэх, үйлчилгээ, /өвчнийг оношлох, эсчлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх, сэргээн засах, эмийн үйлчилгээ г.м/ явуулна. Үүний дотроос хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан сэргээн засах арга хэмжээ онцгой чухал байдаг.

Нэгдсэн эмнэлэгт 1-ээс дээш давхарт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан өрөө тасалгаа төлөвлөсөн бол цахилгаан шатыг хүн тээврийн-1, ачааны-1 заавал төлөвлөнө.

Цахилгаан шатны тасалгааны гүн 2.1м-ээс багагүй байна.

Цөөн давхрын нэгдсэн эмнэлэгт шатны өргүүрийг төлөвлөж болно.

Нэгдсэн эмнэлгийн 1-р давхарт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үйлчлэх /эмчлэх, зөвөлгөө өгөх/ зорилгоор янз бүрийн мэргэжлийн эмч нарын өрөө, эмчилгээний танхимуудыг төлөвлөнө. Эзэлхүүн төлөвлөлтийн шийдлийг дараах хүснэгтээс үзнэ. Үүнд:

Үйлчлэх хүмүүсийн тоо	Үйлчилгээний хүрээ / м /	Хүн амын нягтрал хүн/га	Барилга байгууламжийн төрөл	Эмч нарын мэргэжил, тоо	Эмчлэх танхимын нэр, тоо
1500~1700	300	180 хүртэлх	Жижиг нэгдсэн эмнэлэг, явуут эмчилгээний эмнэлэг /амбулатори/	Ерөнхий эмч-1 Шүдний эмч-1	Дотрын-1 Шүдний-1
4000~6000	300	180~300		Дотрын эмч-2~3 Хүүхдийн эмч-1~1.5 Шүдний эмч-2 Эмэгтэйчүүдийн эмч-0.5 Сэтгэл мэдрэлийн эмч-0.5	Дотрын-2 Хүүхдийн-1 Шүдний-1 Эмэгтэйчүүдийн-1
8000~10000	300	300-аас	-	Дотрын эмч-5 Хүүхдийн эмч-2~2.5 Шүдний эмч-5~6 Эмэгтэйчүүдийн эмч-1 Сэтгэл мэдрэлийн эмч-1	Дотрын-5 Хүүхдийн-2~2.5 Шүдний-5~6 Эмэгтэйчүүдийн-1 Сэтгэл мэдрэлийн-1

13.1 ЭДЭЛБЭР ГАЗАРТ ТАВИХ ШААРДЛАГА

Нэгдсэн эмнэлгийн хотын дотор хөдөлгөөн хязгаарлагдмал хүмүүс амар хялбар хүрч болох явган болон тэргэнцрийн замтай, тээврийн нөхцлийг зайлшгүй хангасан газар байршуулхаар сонгоно.

Уушиг, зүрхний өвчтэй, өндөр настан, бие эрхтэн дутуу хүний амрахад зориулж явган хүний замын дагуу 100м тутамд амрах хэсгийг төлөвлөнө.

Хөгжлийн бэрхшээлтэй болон настай хүмүүсийн эрүүл мэндийн байдлаас хамаарч амралгүй туулах явган замын ашигтай урт /нэг чиглэлд/ 100~150м-ын хооронд хэлбэлзэнэ.

Тусгаар өрөө тасалгаа.

Хөлийн өрөөнд нэгдсэн эмнэлгийн зориулалт, орон зайн бүтэц, үйлчилгээний тухай мэдээллүүд төвлөрсөн байх ёстой. Сул хараатай хүмүүсийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан байр, лавлах хэсэгт амархан хүрч болохыг заасан заалт тэмдэг, шатууд /цахилгаан болон энгийн/ болон бие засах газрын байршил, давхар бүрийн өрөө тасалгааны зориулалт, эргэлтүүд, зорчих замын чиглэлүүдийг заасан тэмдэглэгээнүүдийг заавал байршуулна.

Эмчийн хүлээн авах цаг, байр зэргийг дуу авианы, тусгай дохиоллуудаар мэдэгдэх аргуудыг нэмж хэрэглэж болно.

Орцын хөлийн өрөөнд бие эрхтний эмгэгтэй хүмүүс хувцсаа солиход зориулж сул орон зайг тусгаарлан төлөвлөж өгнө.

Хүүхдийн нэгдсэн эмнэлгийн орцын хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн болон нярай хүүхдийн тэргэнцрийг хадгалах өрөө, хөхүүл хүүхэд манцуйлах ширээ, тавцанг төлөвлөнө. Нэгдсэн эмнэлгийн орцын хэсэгт хөтөч нохой болон бусад туслах хэрэгслүүдийг хадгалах өрөө төлөвлөнө.

Мөн автомат-харилцуур утас төлөвлөх ба хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ашиглахад зориулж 1~2 утасны төхөөрөмжийг шалнаас 0.85~1.1м-т байршуулна.

Хувцасны өлгүүр, бүртгэх хэсэг, лавлагааний хэсгийн лангууны тодорхой хэсгийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үйлчлэхэд зориулж тавцанг шалнаас 0.8м-ээс багагүй өндөрт төлөвлөнө.

Эмнэлгийн орцын хөлийн өрөөнд хөгжлийн бэрхшээлтэй хүнд тохируулж ариун цэврийн өрөөг 1-ээс доошгүй төлөвлөж тусгай төхөөрөмжөөр тоноглоно. Нийтийн бие засах хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй хүний тусгай тасалгааг /эрэгтэй, эмэгтэй тус бүр 1/ төлөвлөнө.

Тулгуур эрхтний тоноглолтой хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ая тухыг хангахад зориулж хөлийн өрөөнд сул орон зай төлөвлөн ханын тавиур, ширээ, бариул, өлгүүр дэгээнүүдийг 0.8~1.2м-ийн өндөрт төлөвлөнө.

Өвчтөнийг бүртгэх өрөөнд тэргэнцэртэй хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрөө эмчид хандахад зориулсан ая тухтай орон зайг төлөвлөнө.

Эмчийн танхимын өмнө хүлээх бүсэд тэргэнцэртэй хүний байрыг төлөвлөнө.

Өвчтөнийг хүлээн авах танхимд хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзлэг, үйлчилгээ үзүүлэхэд зориулж тэргэнцрээр эргэх боломжийг хангасан орон зайг зайлшгүй төлөвлөнө.


Мэргэжлийн чиглэлээр үзлэг хийх танхимын /нүд, хамар, хоолой/ хаалгыг өвчтөн саадгүй нэвтрэхэд зориулж 0.85м-ээс багагүй өргөнтэй төлөвлөнө.

Нэгдсэн эмнэлгийн төлөвлөлтийн шалгуур үзүүлэлт дараах болно.


- Эмнэлгийн орцонд налуу замыг заавал төлөвлөнө.
- 1.1х1.5м-ээс багагүй хэмжээтэй цахилгаан шаттай байх.

- Өрөө тасалгааны шалны гадаргуу нэг түвшинд байх.
- Эмнэлгийн барилгын байгуулалт, овор хэмжээ олгоход энгийн бөгөөд тодорхой байх.
- Барилгын тулгуур хийцүүд /багана, тулгуур/ өвчтөний хөдөлгөөний замд саад болхооргүй төлөвлөгдсөн байх.
- Тэргэнцэртэй хүн эргэлтийн хөдөлгөөн хийх боломж хангагдсан байх зэрэг болно.


Эдгээр шалгуурууд нь эмнэлгийн дотоод орон зайд /хөлийн өрөө, хонгил, танхим, ариун цэврийн өрөө г.м/ хөдөлгөөн хязгаарлагдмал хүмүүст зориулж өрөө тасалгаа, тоноглолуудыг /хаалга, шат, ханан дахь бариулууд, өлгүүр, шалны тусгай гадаргуу, мэдээллийн дохиоллууд/ хэр зэрэг хангалттай төлөвлөсөн онцгой шаардлагуудаар илэрч байх ёстой. Эдгээр шаардлагууд орон сууцны барилгын 1-р давхарт, худалдааны танхимын дотор болон тусгаар төлөвлөгдөх эмийн сангийн төлөвлөлтөнд нэгэн адил хамаарагдана.




Эмчийн өрөө




Эмэгтэйчүүдийн үзлэгийн өрөө





Шүдний эмчийн өрөө




Ахлах сувилагчийн өрөө



Боолтын өрөө





13.2 ЭМЧИЛГЭЭНИЙ ДАСГАЛД ЗОРИУЛСАН ОРОН ЗАЙН БАЙРЛАЛ

Нэгдсэн эмнэлэгт эмчилгээний биеийн тамирын дасгал хийхэд зориулсан өрөөг хөгжлийн бэрхшээлтэй хүн ашиглах боломжтой төлөвлөнө. Үйлчлэх хүмүүсийн тооноос хамааруулан уг өрөөний урт 10~12м, өргөн 6~9м байна. Шүршүүрийн тасалгааны уртыг /хамгийн бага/ 2м хүртэл ихэсгэж болно

Физик эмчилгээний танхим дотор тэргэнцэртэй хүн эргэх боломжийг тооцсон байна.

Цахилгаан гэрлэг эмчилгээний тасалгаа 2.2х2.2м хэмжээтэй байна.

Иллэг хийх танхимын хэмжээ 3.5х3.1м байх ба тэргэнцэртэй хөгжлийн бэрхшээлтэй хүн эргэх хөдөлгөөн хийхийг тооцсон байх ёстой. Дотрын танхимын хэмжээ 3.2х3.3м-ээс багагүй байх ёстой.


Усанд орох шүршүүрийн тасалгаа руу тэргэнцэртэй хүн шилжих хөдөлгөөн хийх боломжийн орон зайтай, хөгжлийн бэрхшээлтэй хүн тулах, барих тусгай төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

Усан иллэг хийх өрөөг хөгжлийн бэрхшээлтэй хүн тэргэнцрээс усанд орох онгоц руу шилжих тусгай төхөөрөмжөөр тоноглоно.


Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг сэргээн засах эмчилгээ хийх хэсэгт усанд орох онгоц руу шилжих тусгай төхөөрөмжөөр тоноглоно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг сэргээн засах эмчилгээ хийх хэсэгт усанд орох онгоцтой тасалгаа, хувцас тайлах тасалгааг тусгаар төлөвлөн, тусгай төхөөрөмжөөр тоноглоно.



Биеийн тамирын эмчилгээний өрөөний дэргэд шүршүүртэй танхим, хувцас тайлах тасалгааг хөгжлийн бэрхшээлтэй хүн ашиглахад хялбар байх нөхцлийн тооцож төлөвлөнө. Хувцас тайлах тасалгааг дасгал хийх өрөөтэй эсвэл шүршүүрийн танхимтай шууд харьцхаар төлөвлөнө.




Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан дасгалын өрөө




Шүршүүртэй дасгалын өрөө




Шүршүүртэй дасгалын өрөө




Иллэгийн өрөө




Боолтны өрөө





Усан иллэгийн өрөө







Усан эмчилгээний өрөө

хөгжлийн бэрхшээлтэй
хүний шилжих хөдөлгөөнд
зориулсан тоноглолтой



Гэрлэн эмчилгээний өрөө



13.3 СУРГУУЛИЙН БАРИЛГЫН АНГИ, ТАНХИМ ОРОН ЗАЙН ТӨЛӨВЛӨЛТ

Ердийн ерөнхий боловсролын сургуульд тулгуур эрхтний бэрхшээлтэй /тэргэнцэртэй, таягтай, бусад туслах тоноглолтой/ ухаан мэдрэл эрүүл хүүхдийг сургаж болно. Сургуульд хөгжлийн бэрхшээлтэй бусад багш, ажилтан, хүүхдийн эцэг эхчүүд байхыг үгүйсгэж болохгүй. Мэдрэлд нөлөөлсөн гэмтэлтэй, хүний асаргаа сувилгааг байнга шаардсан хөгжлийн бэрхшээлтэй, харааны бэрхшээлтэй, хэл яриа, сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийг тусгай сургуульд сургана.

Төлөвлөлтөөр сургуулийн барилгын орцын хэсэгт тэргэнцрийн налуу замыг 1:15, 1:12-аар байгуулнаа. Налуу замын өргөн 0.9м-ээс багагүй, 2 талдаа хашлагатай, хашлагуудад үргэлжилсэн бариулыг 0.65:0.75м-ийн өндөрт байгуулна. Дүүргэлт 30~40 хүүхэдтэй анги, танхимуудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тусгай ширээ, сандал, тэргэнцрээр эргэх орон зайг төлөвлөнө. Ширээний тавцангийн өндөр 0.65м-ээс багагүй, тавцангын доогуур тэргэнцрийн урд дугуй өвдөг чөлөөтэй орох зайтай байна. Ширээг ангийн голын эгнээний эхний хэсэгт байрлуулах ба гарах гарцад хамгийн ойр зайд байна. Ангийн орох хаалганы хажууд тэргэнцэр тавих жижиг өрөөг /1.2х1.2м/ гаргаж өгнө. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сандал тавих зайг /1.2х0.6м/ төлөвлөнө. Тэнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хувцасаа өлгөх өлгүүрийг 0.9~1.1м-ийн өндөрт байршуулна. Шатны дэргэд тэргэнцэртэй хүүхдэд зориулсан өргүүрийг төлөвлөнө. Бие засах хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулж тусгай тоноглолтой тасалгааг /эр-1, эм-1/ төлөвлөнө. Үүнд: бие засах суултуур, хөтөвч /писсуар/, тосгуур, бариулууд, тэргэнцэр түр тавих талбай, толь зэрэг болно. Сургуулийн номын сан, хооллох газарт 1~2 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сул ширээ сандал орон зайг төлөвлөнө. Тэргэнцрээр явах хэсгүүдийн /хонгил, анги, танхим, заал/ шалны гадаргуу жигд, хальтардаггүй материалаар хийгдсэн байна.




Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн барилгыг тусгай БНБД-ийг үндэслэн төлөвлөнө. Ердийн ЕБС-ийн барилгад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан төлөвлөлтийг тухайн орон нутгийн захиргааны шийдвэрээр гүйцэтгэнэ. Төлөвлөлтийн шаардлага өгөгдлүүдийг гарын авлагын 1 хэсгээс /хөгжлийн бэрхшээлтэй хүний эргономик, антропометр/ авч хэмжигдэхүүнүүдийг нь 8~10%-иар багасгаж төлөвлөлтөнд хэрэглэнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан ажлын байрыг гэрэлтүүлэг, агаар сэлгэлт сайтай төлөвлөх ёстой.

Ажлын өрөөний орон зайн хэмжээг уг гарын авлагын 4 хэсэгт тусгасан /хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тавилга, тоног төхөөрөмжүүд/ өгөгдлүүдийг үндэслэн тогтоож, ажлын байрны төлөвлөлтийг боловсруулна.


Төлөвлөлтийг боловсруулахдаа гарын авлагын 1 хэсгийн заалтуудыг мөрдлөг болгоно.

13.4 ХҮЛЭЭЛГИЙН ТАНХИМ, ХҮЛЭЭН АВАХ




14. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНД ЗОРИУЛСАН ТАВИЛГА, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖҮҮДИЙН БАЙРШЛЫН ХЭВИЙН ХЭМЖЭЭ

14.1 ЛАНГУУ, ТАВИУР, ТАВЦАН, ШҮҮГЭЭ



Лангуу, тавиур, тавцан




Тавиур, шүүгээний өндрийн хэвийн хэмжээ

14.2 ШИРЭЭ, ТАВИУР


Ширээний дэргэд тэргэнцэртэй хөгжлийн бэрхшээлтэй хүний зай байхыг бодолцох.

Ширээний хоорондуур цааш нааш явж болох орон зайг мөн бодолцох ёстой.




Хоолны ширээний өргөн, өндөр, гүн

14.3 ШИРЭЭ, ТЭРГЭНЦРИЙН ЭЗЛЭХ ОРОН ЗАЙ



14.4 ЦАХИЛГААН ХЭРЭГСЛИЙН БОЛОН ГЭРЛИЙН УНТРААГУУР, ЗАЛГУУРУУД

Унтраагуур ба цахилгааны залгуурууд нь тэргэнцэтэй хүн төвөггүй хүрэх хэмжээнд бэхлэгдэх ёстой.



15. ДОХИОЛЛЫН СИСТЕМ, ТАНИХ ТЭМДЭГ


Аюул ослоос хөгжлийн бэрхшээлтэй хүнийг аврах дохионд:


- Дуут дохио.
- Доргио чичэрхийлэлтэй дохионууд хамаарагдана.

Эдгээр дохиоллууд нь хараа муутай хүмүүст аваар ослоос сэрэмжлүүлэх хэрэгслийг багтаах ёстой.


Сонсгол муутай хүмүүст зориулсан нүдэнд харагдах дохиоллын төхөөрөмжүүдийг бэлтгэнэ.


Доргионт дохиоллын төхөөрөмжүүдийг дэрэн доор нь тавьж амархан залгаж болохоор байх ёстой.





15.1 БАРИЛГЫН ГАДНА ОРЦ ГАРЦЫН ДОХИОЛЛЫН ТОНОГЛОЛ





15.2 ХАРИЛЦАА ХОЛБООНЫ СИСТЕМ

Нийтийн харилцуур утас

- Тэргэнцэртэй хүмүүс утасны бүхээгт урд болон хажуу талаараа хүрэх хангалттай талбай, орон зайгаар хангагдсан байх ёстой.
- Бүхээгний хаалга, суудал зэрэг нь тэргэнцэр хэрэглэгчдийн замыг хаах ёсгүй. Эвхэгддэг суудал байж болно.
- Утасны дээд хэсэг нь сууж буй хүн төвөггүй хүрэхээр байх.
- Утасны доогуур өвдөг орох зайтай байх.
- Утас, дардаг товчлууртай байвал зүгээр.
- Утасны гар нь урт залгуур утастай байх.

Сонсголын бэрхшээлтэй хүмүүст зориулсан утсан харилцааны төхөөрөмжүүд

- TDD-г төлбөрт утасны бүхээгний зэргэлдээ суурилуулсан байвал зүгээр.
- TDD-н таних тэмдгээр тодотгогдсон байх хэрэгтэй.
- Төлбөрт утас дуу тохируулагчтай байх хэрэгтэй.
- Сонсгол муу хүмүүст ирж буй дуудлагыг мэдрүүлэх, сэрэмжлүүлэх үүднээс конторын барилга, зочид буудлын барилгын өрөөнүүд нь харагдах, сонордуулах төхөөрөмжүүдээр хангах хэрэгтэй.

Сонсголын төхөөрөмжүүд

- Хурал чуулган, зөвлөлгөөн, уулзалт хийх өрөөнүүд нь сонсгол муу хүмүүст зориулсан төхөөрөмжүүдээр /сонсголын аппарат, чихэвч/ хангагдсан байх хэрэгтэй.
- Зах зээлийн одоогийн нөхцөлд сонсголын янз бүрийн төхөөрөмжүүд байдаг. Үүнд: радио давтамжийн системүүд, хэт авианы дамжуулах төхөөрөмжүүд, сансрын холбоо г.м
- Сонсголын төхөөрөмжүүдийн театр, концертын танхим, стадион /музей, галерей, зоо парк, зугаа цэнгэлийн газар/ зэрэг үзвэрийн зориулалттай газруудад хэрэглэж болно.


Факс

- Факс нь сонсгол муутай хүмүүст харилцаа холбооны чухал хэрэгсэл бөгөөд тэдний гэр орон, шуудан, худалдааны болон бусад олон нийтийн газарт байх зайлшгүй хэрэгслийн нэг юм.

Брайл тэмдэг


- Брайл тэмдэгтүүд нь хараа муу хүмүүс олноороо цугладаг газруудад хангалттай байх ёстой.

15.3 ОЛОН НИЙТИЙН БАРИЛГАД ТӨЛӨВЛӨХ ХАРИЛЦУУР УТАС




Утасны тавцангын өргөн, өндөр, гүн

15.4. ГУДАМЖИНД БАЙРШУУЛАХ ХАРИЛЦУУР УТАС



15.5. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ХАРАХ БҮС




15.6. ИЛ ЦУХУЙСАН МӨРГӨЦГҮҮД

Ил гарсан мөргөцгүүд болохыг заах тэмдгүүд, модны мөчрүүд, цахилгаан утас, татлага олс, харилцуур утасны бүхээг, вандан, тавцан болон чимэглэлийн элементүүдийг хараа муутай хүмүүсийн таягны хөдөлгөөний даялалд тохируулан суурилуулах хэрэгтэй.

Хараа муутай хүмүүст сэрэмжлүүлэх саадыг шат болон цахилгаан шатны доор хийх хэрэгтэй.


Явган зам, танхим, хонгил, нэвтрэх зам, эгнээ хоорондын зай болон бусад эргэлт бүхий газруудын ослын эрсдлийг багасгах үүднээс гол зай нь чөлөөтэй, цэвэр байх ёстой.






16. ТЭРГЭНЦЭРТЭЙ ХҮНИЙ СУУДАЛ / ҮЗВЭРИЙН ТАНХИМ /

Хурал цуглааны зориулалттай танхим, үзвэрийн зориулалттай бусад үйлчилгээний барилгуудад тэргэнцрийн зай гаргах.



Бие мах бодийн эмгэгтэй хүмүүст зориулсан хялбар суудлуудыг янз бүрийн байрлалаар зэхэж бэлтгэх.







17. СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ЗОРИУЛСАН СУУДАЛ



18. ТАНИХ ТЭМДГҮҮД, СТАНДАРТ ХЭМЖЭЭ




Таних тэмдгүүд нь өнгөөр ялгагдсан байхаас гадна хараа муутай хүмүүс тэмтэрч ойлгож болохуйц хотгор гүдгэр гадаргуутай байх.

Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн жирийн тэмдэг, өнгөний ялгаа нь


- Ногоон өнгө – аюулаас хамгаалах болон явахыг
- Шар өнгө – эрсдэл байж болох болгоомжлолыг
- Улаан өнгө – аюул ослыг заана

Барилгын дагуу тэмдэг дохионы ойлгомжтой систем хэрэглэх. Зүг чигийн өөрчлөлт бүр дээр дохио тэмдгүүд нь нэгэн хэвийн, ижил түвшинд байрлах ёстой.

Тэмдэг дохиог байршуулах өндрийн хэмжээг “Ил цухуйсан мөргөцөгийн заавар”, “Таних тэмдэг байршуулах хэвийн хэмжээ”-ний дагуу тогтооно.



19. ОЛОН УЛСЫН СТАНДАРТ ТЭМДЭГ





Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



Хангарди ордон, Ц.Жигжиджавын гудамж-7/1
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0011



70118060



www.standard.ub.gov.mn



Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт,
зохицуулалтын газар